

Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

2-р Хичээл

Бурханы Хаанчлал

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гурав Дахь Мянгын Үйлчилгээ

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АВ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчилгээ нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчилгээ бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчилгээнд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр дахин давтагдашгүй, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашигласан цуврал хичээлүүдийг бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчилгээнд маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг бөгөөд хувь хүмүүс, бүлгээрээ, сургууль дээрээ болон цахим хэлбэрээр ашиглахаар бүтээгдсэн.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчилгээ нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчилгээ нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчилгээний тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Гарчиг

Удиртгал	1
САЙНМЭДЭЭ	1
Утга санаа	2
Бурханы Хаанчлал	3
Ганхашгүй Бүрэн эрх	4
Хаанчлалын илрэл	4
Ойлголтын хөгжил ба түүхэн ач холбогдол	5
Израилийн Уналт	5
Израилийн Найдвар	7
ИРЖ БУЙ ХААНЧЛАЛ	9
Хүлээлтүүд	9
Гурван үет Ялалт	14
Дайсны Ялагдал	14
Итгэгчдийн Аврал	18
ДҮГНЭЛТ	21
ХАМТРАГЧИД	22
ҮГСИЙН ТАЙЛБАР	27

Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

Хоёрдугаар хичээл

Бурханы Хаанчлал

УДИРТГАЛ

Та бид ээдрээтэй түүхийг уншихдаа олон нарийн хэсгүүдийг нь орхигдуулах гээд байдаг шүү дээ. Тэгвэл үүнээс сэргийлэх нэг арга бол тухайн түүхийн хамгийн чухал хэсгүүдийг тодорхойлоод, тэгээд тэдгээрийг дахин дахин лавлаж харах явдал юм. Гол үйл явдлуудыг үргэлж санаж байх нь эдгээр нарийн хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг харахад амар болгодог. Олон талаараа Шинэ Гэрээний теологийг ойлгоход бид яг л ийм бэрхшээлтэй тулгардаг. Бичвэрүүдийг уншиж эхлээд л бид бүрэн ухаж ойлгохгүй олон нарийн хэсгүүдтэй тулгардаг. Тиймээс бид Шинэ Гэрээн дэх гол санаануудыг олж дахин дахин лавлаж харахдаа тун анхааралтай хандах ёстой юм.

Энэ бол *Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ* гэсэн цувралын маань хоёрдугаар хичээл бөгөөд “Бурханы хаанчлал” гэдэг сэдэвтэй. Уг хичээлээр бид Шинэ Гэрээний хамгийн алдартай сургаалуудын нэг болох Бурханы Хаанчлалын тухай тайлбарлана. Бурханы Хаанчлал гэдэг нь Шинэ Гэрээнд маш чухал сэдэв билээ. Үүнийг зөв ойлгож чадвал Шинэ Гэрээний теологи бол *хаанчлалын* теологи юм гэдгийг харах болно. Өөрөөр хэлбэл Шинэ Гэрээний бичээчдийн бичсэн бүхэн ямар нэг хэмжээгээр Бурханы хаанчлалыг тайлбарлаж, цааш дэлгэрүүлэхэд чиглэсэн байдаг гэж хэлж болох юм.

Бид Шинэ Гэрээний теологи дахь Бурханы хаанчлалын тухай ойлголтыг хоёр талаас нь авч үзнэ. Эхлээд бид Шинэ Гэрээний бичээчид хаанчлалын Сайнмэдээ буюу авралын зарыг чухам юу гэж үзэж байсанд анхаарлаа хандуулна. Дараа нь ирж буй хаанчлал нь тэдний бичсэн бүхэнд хэрхэн нөлөөлсөн тухай үзнэ. Энэ хоёр сэдэв бидэнд Шинэ Гэрээ нь бүхий л талаараа Бурханы хаанчлалын тухай сургаалд түшиглэдэг гэдгийг ойлгоход тусална. Тэгэхээр одоо хаанчлалын Сайнмэдээний тухай эхлээд үзье.

САЙНМЭДЭЭ

Шинэ Гэрээний теологи нь тун ярвигтай гэдэгтэй бүгд санал нэг байдаг. Гэхдээ хүн бүрийн ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой Шинэ Гэрээний нэг сургаал байдаг гэвэл тэр нь Сайнмэдээ л байх нь лавтай. Үнэндээ бид Христийн Сайнмэдээг ойлгохгүй бол Шинэ Гэрээний теологийн аль ч талыг ойлгох боломж маш хязгаарлагдмал юм. Үүнийг бидний олонх нь хүлээн зөвшөөрөх байх. Гэхдээ эндээс маш чухал асуулт урган гарч ирдэг. Яагаад “Сайнмэдээ” нь Шинэ Гэрээний теологид тийм онц ач холбогдолтой байдаг юм бэ? Яагаад энэ нь Шинэ Гэрээний олон энгийн онол дундаас онцгой гэж? Сайнмэдээ нь Бурханы хаанчлалын талаарх өргөн хүрээний сургаалтай холбоотой байдаг. Тиймээс энэ нь Шинэ Гэрээний теологид маш чухал гэдгийг бид удахгүй үзнэ. Бурханы хаанчлалын тухай

Сайнмэдээний энэхүү онол сургаал нь Шинэ Гэрээний теологийг тал бүрээс нь хэлбэржүүлдэг.

Хаанчлалын Сайнмэдээг бид гурван алхмаар үзэх болно. Эхлээд бүгдээрээ Сайнмэдээ гэдэг үгний утга санаанд анхаарлаа хандуулна. Дараа нь Бурханы хаанчлалын талаарх үндсэн үзэл санааг судална. Харин эцэст нь бид Библийн түүхэнд дэх Бурханы Хаанчлал хэмээх ойлголтын хөгжил ба түүхэн ач холбогдолыг мөшгөн судлах болно. Ингээд хамтдаа Бурханы хаанчлалын Сайнмэдээний утга учрын талаар үзэцгээе.

УТГА УЧИР

Хаанчлалын Сайнмэдээ гэдэг бол Их Эзэн Хааны бидэнд тунхагласан Сайхан мэдээний талаар ярьж буй арга зам юм. Ялангуяа бид Есүсийн тухай Шинэ Гэрээнд юу гэж тунхагласныг харах юм бол “хаан ирлээ” гэсэн байдаг. Гэхдээ зөвхөн “хаан ирлээ” гээд зогсохгүй Есүсийн ноёрхол ба хаанчлалыг тунхагладаг. Ингэхдээ Түүний үхэл ба амилал нь хаанчлалыг нь бататгасан хэмээн тунхагласан. Тиймээс энэхүү Сайнмэдээ бол аль хэдийн болоод өнгөрсөн зүйлийн талаарх тунхаглал юм гэсэн утгатай. Энэ мэдээ нь биднийг хэрхэн амьдрахад нөлөөлдөг. Гэхдээ Есүс ирсэн гэдэг нь Сайнмэдээ юм. Тэрээр үхсэнээрээ маш ер бусын байдлаар үхлийг ялан дийлсэн ... Тиймээс энэ сайн зүйл аль хэдийн болсон гэдгийг Бурхан бидэнд тунхаглаж байгаа гэсэн утгатай. Хэдий тийм ч амлалтууд нь сайн мэдээний дотор одоо ч биелсээр байгаа нь мөнхөд ч биелнэ гэсэн үг юм.

— Др. Ричард Линтс

Лук 4:43 дээр Есүс үйлчлэлийнхээ зорилгыг хэрхэн дүгнэснийг харцгаая. Энэ нь:

“Би Бурханы хаанчлалын Сайнмэдээг хүргэх учиртай” гэжээ (Лук 4:43).

Энэхүү Лук 4:43-р эшлэлд “Сайнмэдээ” гэдэг үг ганц удаа дурдагдсан хэдий ч Сайнмэдээний тухай хоёр ч ойлголтыг энд өгүүлдэг. “Сайн мэдээ” гэдэг үг нь Грек хэлний *евангелион* гэдэг нэр үгнээс гаралтай бөгөөд Шинэ Гэрээнд 76 удаа гардаг. *Евангелион* гэдэг үгийн гарал зүйг харвал энэ нь ямар нэгэн “сайн мэдэгдэл/зарлал” эсвэл “сайн үг” гэсэн утгатай.

Гэвч Есүс энд мөн “сайн мэдээг тунхаглах ёстой” гэснийг анзаараарай. Грек хэл дээр “тунхаглах” гэдэг үйл үгийг *евангелизо* гэдэг. Энэ үг нь Грек хэлний *евангелион* гэдэг үгтэй нэг үндэстэй. Энэ нь “сайн мэдээг тунхаглах эсвэл зарлах” гэсэн утгатай ба Шинэ Гэрээнд 54 удаа дурдагдсан байдаг. Ийнхүү олон удаа дурдагдсан нь энэ үг Шинэ Гэрээг бичсэн хүмүүст ямар чухал байсныг илтгэдэг.

Өнөөдөр маш олон Эвангелийн итгэгчид Сайнмэдээ бол хувь хүн Христ дотор авралыг олж авахын тулд хийх ёстой алхмуудын тайлбар юм гэж боддог. Гэвч энэ нь Есүсийн санаа байгаагүй. Бид хэрхэн Христийн дагалдагч болох тухай хуваалцахад үргэлж бэлэн байх ёстой. Гэсэн хэдий ч Бичвэр дэх Сайнмэдээ нь түүнээс ч илүү чухал зүйлийн тухай байдаг. Энэ нь хэн нэг хүний эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн авралын тухай гэхээсээ илүү Бурханы хаанчлалын ялалтын тухай юм гэдгийг бид үзэх болно.

Үүнийг ойлгохын тулд бид Шинэ Гэрээний бичээчид Хуучин Гэрээний Грек орчуулга болох Септуагинтаас “Сайнмэдээг тунхагла” гэсэн үгийг эш татсаныг анхаарах хэрэгтэй. Септуагинтад бидний өмнө дурдсан үг болох *Эвангелизо* гэсэн үгийг 20 удаа ашигласан байдаг. Энэ үг бол Еврей хэлний *басар* буюу “Сайнмэдээг авчрах ба зарлан тунхаглах” гэж орчуулдаг. Гэхдээ 1 Самуел 31:9 болон 2 Самуел 18:19 зэрэг эшлэлүүдэд энэ үгийг хаад болон хаанчлалын тухай, тэдний *тулаанд ялсан* тухай сайн мэдээг илэрхийлдэг. Шинэ Гэрээнд ч гэсэн “Сайнмэдээ” гэдэг үгийг ихэнхдээ Бурханы хаанчлалын ялалтын тухай холбон хэрэглэсэн байдаг Тиймээс энэ уялдааг анзаарах нь тун чухал билээ. Лук 4:43 дээр Есүс хэлэхдээ:

“Би Бурханы хаанчлалын Сайнмэдээг хүргэх учиртай” гэжээ (Лук 4:43).

Гэвч энэ үгийг:

“Би Бурханы хаанчлалын [ялалтын] Сайнмэдээг хүргэх учиртай” гэж орчуулах нь зүйтэй юм. (Лук 4:43).

Шинэ Гэрээнд Бурханы хаанчлалын ялалтын тухай Сайнмэдээ гэж хэлэхдээ онцгой төрлийн ялалтын тухай ярьсан байдаг. Энэ тухай бид энэ хичээлийн төгсгөлд ярилцах болно. Тиймээс анх сонсоход тун хачирхалтай санагдаж болох ч бид Шинэ Гэрээн дэх Сайнмэдээ нь Бурханы хаанчлалын “[ялалтын]” тухай Сайнмэдээ юм гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Хаанчлалын Сайнмэдээ гэдэг нь Бурханы хаанчлалын ялалтын тухай Сайнмэдээ гэсэн УТГА болохыг ойлгосон биз ээ. Тэгвэл одоо Бурханы хаанчлал хэмээх үндсэн ойлголтын тухай үзэхэд бэлэн болжээ гэсэн үг.

БУРХАНЫ ХААНЧЛАЛ

Шинэ Гэрээнд Бурханы хаанчлал нь онцгойлон Сайнмэдээтэй холбоотойгоор дор хаяж долоон удаа дурдагдсан байдаг. “Хаанчлалын Сайнмэдээ” гэдэг үг Матай 4:23; 9:35; болон 24:14; Лук 4:43; 8:1; болон 16:16 дээр, мөн Үйлс 8:12 зэрэг эшлэлүүдэд бага зэрэг л ялгаатай илэрхийлэгдсэнийг харж болно. Ийнхүү олон давтан дурдагдсан нь Сайнмэдээг буюу ялалтын мэдээг Бурханы хаанчлалтай холбох нь ямар чухал болохыг харуулж байна. Гэвч үүнийг ойлгохын тулд бид

эхлээд Есүс болон Түүний дагалдагч нар Бурханы хаанчлал гэж хэлэхдээ чухам ямар утга санааг илэрхийлснийг ойлгох хэрэгтэй.

Бурханы хаанчлал гэдэг нь Бурханы газар буй Бурханы хүмүүсийн дээгүүрх Бурханы захиргааг хэлнэ. Бид Бурханы газар болох Еден цэцэрлэгт, Бурханы хүмүүс болох Адам Ева хоёр Бурхантай харилцаж, Бурхан бүхнийг захирч байсныг Библийн Эхлэл номын 1 болон 2-р бүлгээс хардаг. Гэвч гэм нүглийн улмаас энэ захиргаа нурсан. Харин Бурхан эхлээд Абрахамаар, дараа нь түүний үр удмаар, эцэст нь Мосегоор дамжуулан Израилийн ард түмнийг чөлөөлсний дараа хаанчлалаа дахин сэргээдэг. Бурханы газар болох Канаан нутагт, Бурханы ард түмэн болох Израильчуудыг Бурхан захирч байсан. Харин бүр хожим нь энэ загвар Христийн ирэлтээр бүрэн дүүрэн биеллээ олсон юм. Бурхан Өөрийн томилсон Хаан болох Христээр дамжуулан захирдаг болохыг харж болно. Бурханы ард түмэн гэдэгт Иудейчүүд, харь үндэстнүүд болон бүх үндэстний хүмүүс, бүх овог, бүх хэлтнүүд багтдаг. Бурханы газар гэдэг нь тодорхой байршил бүхий газар гэхээс илүү бидний тэнгэрлэг гэр болсон Шинэ Иерусалимыг хэлж байна ... Тиймээс бид Шинэ Гэрээн дэх Бурханы хаанчлал нь Христээр дамжуулан дэлхий даяар тархсан Түүний бүх овог үндэстэн, хэлтнүүдийн дээр оршин байдаг болохыг харж болно. Энэ нь газар зүйн тодорхой байршилд бус харин бидний сүнсний гэр орон болсон тэнгэрийн улсад бий. Мөн Шинэ Гэрээ бидэнд Бурханы хаанчлал нь Христийг эргэн ирсний дараа ямар байхыг зэрвэсхэн харуулдаг. Хэдий энэ дэлхий дээрх Бурханы хаанчлал нь одоогоор зарим талаараа нууцлагдсан байгаа ч Христ эргэн ирэх үед бүрэн тодорхой болно. Тийнхүү өвдөг бүр сөхөрч, хэл бүр Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрнө. Тэгээд Бурхан Хаан болох Христээр дамжуулан Өөрийг нь мэддэг, Эцэг минь хэмээн дууддаг ард түмнээ тэнгэрлэг Шинэ Иерусалимдаа төгс төгөлдөр байдалд захирна.

— Др. Константин Р. Кэмпбелл

Библид Бурханы хаанчлалыг хоёр янзаар тодорхойлсон байдаг. Нэг талаас Бурханы хаанчлал нь Түүний ганхашгүй бүрэн эрх буюу бүх бүтээлүүдийн дээгүүрх Түүний хувиршгүй захиргааг хэлдэг. Мөн түүнчлэн, Хаанчлалын илрэл буюу Бурхан хүн төрөлхтний түүхийн туршид Өөрийн хаанчлалыг хэрхэн илчлэн илэрхийлж ирсэн талаас нь мөн авч үздэг. Эхлээд түүний ганхашгүй бүрэн эрхийн тухай ярилцъя.

Ганхашгүй бүрэн эрх

1 Шастир 29:11 болон 1 Тимот 6:15 дээр бүх бүтээлийг Бурханы хаанчлал хэмээсэн байдаг. Учир нь Бурхан бүтээсэн бүхнээ үргэлж захирсаар ирсэн бөгөөд захирсаар ч байх болно. Бичвэрт Бурханы бүрэн эрх нь тэнгэр ба газар гэсэн хоёр түвшинд хамаатай гэдгийг бид үргэлж санах хэрэгтэй.

Тэнгэрийн хувьд 1 Хаад 8:27 дээр Бурханы хаант засаглалын тухай өгүүлсэн байдаг. Энэхүү эшлэлд Соломон “тэнгэр болон тэнгэрсийн тэнгэр ч” бүтээгдсэн бөгөөд “[Бурханыг] багтааж чадахгүй” гэж тодорхой хэлсэн байдаг. Гэсэн ч Бурхан хүлцэнгүй байж, Өөрийн бүтээлүүдийнхээ өмнө Өөрийгөө илчилсээр байдаг билээ.

Исаиа 6:1 ба 2 Шастир 18:18, Иов 1:6, Дуулал 82:1 болон Даниел 7:9-10, мөн Шинэ Гэрээний Лук 22:30, Илчлэл 4–6-р бүлэгт тэнгэр бол Бурханы оршдог газар гэжээ. Энэ нь бүхий л үйл хэрэг өрнөдөг үзэгдэх энэ газар дэлхийн дээгүүр оршдог юм. Бурхан тэнгэрт хаан ширээнд заларч, тайлан хүлээн авч, залбирлуудыг сонсож, ажиглан, төлөвлөгөө гаргаж, тушаалуудаа буулгадаг. Тэрээр сүнслэг бүтээлүүдээрээ дамжуулан газар дэлхий дээрх хүслээ биелүүлдэг. Мөн заримдаа Өөрийн оршдог газарт сонгосон хүмүүсээ үзэгдлээр дамжуулан оруулж, Өөртөө үйлчлүүлэхээр дууддаг. Тэрээр тэнгэрлэг шүүх суудалдаа буруу, зөвийг шүүн тогтоодог. Ингэхдээ шударга ёс болон өршөөлийнхөө дагуу сүнслэг бүтээлүүд, хувь хүмүүс болон үндэстнүүдэд зохих шийтгэлийг нь өгдөг. Гэхдээ Бурханы тэнгэрлэг үйлс нь тэнгэр дэх хаанчлалд зөвхөн хөтөлдөггүй. Харин доорх хаанчлал буюу газар дээрх хаанчлалдаа ч Тэрээр Өөрийн бүтээлүүдээ бүрэн эрхшээн захирдаг билээ.

Библид Бурханы хаанчлалыг тэнгэр ба газар дээрх ганхашгүй бүрэн эрхт хэмээсэн байдаг. Хэдий тийм ч Есүс болон Шинэ Гэрээний бичээчид газар дээрх Бурханы хаанчлалын тухай дурдахдаа Бурханы хаанчлал хэрхэн илэрч байгааг бодож байсан нь лавтай. Хүн төрөлхтний түүхийн туршид Бурхан хаанчлалаа хэрхэн илчилдэг болохыг бид энэ дэлхий дээр харж болно.

Хаанчлалын илрэл

За тэгэхээр бид Бурхан бүтээлүүдээ бүрэн захирсаар ирсэн бөгөөд захирсаар ч байх болно гэдгийг үзлээ. Гэхдээ Бурханы хаанчлалын илрэл гэдэг нь Бурхан Өөрөө тодорхой арга замаар бүтээлийнхээ дээгүүрх бүрэн эрхээ түүхийн туршид илчлэн, харуулж, хэрэгжүүлсээр ирснийг хэлж байна. Тэгэхээр Бичвэр нь Бурхан *тэнгэр* дэх хаанчлалаа хэрхэн илчилснийг баталж байхад Библийн бичээчид нь Бурхан *газар* дээрх хаанчлалаа хэрхэн илэрхий болгосныг тайлбарлахад ихээхэн анхаарсан байдаг.

Эхэнд Бурханд Еден цэцэрлэгт Өөрийн хаанчлалаа нүдэнд үзэгдэхээр бодитоор байгуулсан. Бурхан анхны хүнийг энэхүү ариун дагшин цэцэрлэгтээ суурьшуулж, хаанчлалыг нь дэлхий даяар тархан амьдарч, тэлэх үүргийг өгсөн. Бурханы эрхэм дээд бас ариун дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс газар дэлхийг дүүргэн захирах ёстой байлаа. Гэвч Адам Ева хоёрын хаанчлалын төлөөх энэ ажилд Сатан маш том саад учруулсан юм. Үүнээс болж Бурхан Өөрийн бүтээлийг харааж, хүн төрөлхтний үүргийг улам хүнд хэцүү болгосон. Тэрээр тэднийг Бурханд үйлчилдэг

хүмүүс болон Бурханы эсрэг Сатаны тэрслэлд нэгдсэн хүмүүс гэсэн хоёр хэсэгт хувааж орхисон.

Тэрхүү тэрслэл Библийн түүхийн туршид олон хэлбэрээр Бурханы хаанчлалд саад бэрхшээл учруулсаар ирсэн юм. Харин Бурхан Өөрийг нь эсэргүүцсэн бүхнийг ялах болно гэдгийг Библид дахин дахин сануулдаг. Түүний дүр төрх дэлхийг дүүргэн, захирах зорилгодоо хүрч, Бурханы хаанчлалын гайхамшгууд газар сайгүй илчлэгдэх болно. Тэр үед Бурхан бүхий л тэрслэлийг ялан дийлж, бүх бүтээлүүд Түүнийг бүтээгч Хаан хэмээн хүлээн зөвшөөрөх болно. Элч Паул Филиппой 2:10-11 дээр юу гэж бичсэнийг харцгаая. Энд:

“Энэ нь Есүсийн нэрд Тэнгэр, газар дээр, газрын доорхс бүгд өвдөг сөгдөж, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж Хэл бүхэн хүлээн зөвшөөрөхийн учир ажээ” гэжээ (Филиппой 2:10-11).

Түүхийн эцэст биелэлээ олох энэхүү сүр жавхлантай алсын хараа нь Есүс болон Түүний дагалдагч нарын “Бурханы хаанчлалын Сайнмэдээ” гэж тунхагласан агуу ялалт юм.


За бүгдээрээ хаанчлалын Сайнмэдээг Сайнмэдээний утга учир болон Бурханы хаанчлал гэсэн хоёр талаас нь авч үзлээ. Одоо бүгдээрээ Бурханы Хаанчлалын ялалтыг тунхаглахын түүхэн ач холбогдолд анхаарлаа хандуулцгаая.

ТҮҮХЭН АЧ ХОЛБОГДОЛ

Хаанчлалын ялалтын тухай Сайнмэдээ нь Шинэ Гэрээний теологийн эд эс бүхэнд нэвт шингэсэн бөгөөд. Энэ нь Шинэ Гэрээний бүхий л хэсэгт ил болон далд хэлбэрээр дурдагддаг. Шинэ Гэрээ бичигдэж байсан яг тэр цаг үед Бурханы хаанчлалын ялалтын төлөөх найдвар маш чухал ач холбогдолтой байв. Тиймээс энэ нь Шинэ Гэрээний теологийг бүрдүүлдэг бүхий л хэсэгт нөлөөлсөн юм.

Шинэ Гэрээний теологит Бурханы хаанчлалын тухай ойлголт хэр чухал ач холбогдолтой болохыг бид олон зүйлээс харж болно. Гэхдээ энэ зорилгоор бид хоёр зүйлийг авч үзэхэд хангалттай. Эхлээд бид Шинэ Гэрээний үе хүртэлх Израилийн уналтын тухай үзнэ. Дараа нь Христ ирэх хүртэл Хаанчлалын тухай Израилийн итгэл найдварын ямар байсныг судлах болно. Тэгэхээр одоо Израилийн уналтын тухай үзье.

Израилийн уналт



Бурхан Аврахаам болон түүний үр удмыг хаанчлалын зорилгынхоо төлөө сонгосон.

онцгой амжилт гаргасан байдаг. Үнэндээ Соломон хааны хаант улсын цар хүрээ Израилийг дэлхийн агуу эзэнт гүрнүүдийн тоонд зүй ёсоор оруулж байсан юм. Эдгээр амжилтуудыг эс тооцвол Аврахамын үр удмын үе бүрийнхэн Бурханаас янз бүрээр урвасаар ирсэн. Гэвч Бурхан тэвчээртэй хандаж, тэдэнд гэм нүглээсээ үл хамааран ирээдүй өөд хөгжин дэвжих боломжийг өгдөг байлаа. Харамсалтай нь, Бурханы ард түмэн өөрсдийн гэсэн хаанчлалыг байгуулж, эзэн хааны удам угсаагаа залж, нийслэлдээ сүмтэй болмогц Израилийн алдаа тоо томшгүй болсон. Тиймээс

Гэм нүглээс болж бүх бүтээл болон хүн төрөлхтөн хараал дор амьдрах болсон. Түүнээс хойш Бурхан Аврахам болон түүний үр удмыг сонгож Адам Ева хоёрт анх даалгасан байсан хаанчлалын зорилгыг биелүүлэх үүргийг өгөв. Аврахамын үр удмыг өнөр өтгөн болгоно гэж Бурхан амласан. Бурханы ерөөлийг дэлхий даяар түгээх эхлэлийг тавихын тулд Аврахамын үр удамд тэрхүү Амлагдсан Газрыг өгсөн. Мосе болон Иошуагийн үед Бурхан Израильчуудад Канаанчууд болон тэдний үйлчилдэг сатаны хүчийг ялахад нь тусалсан. Үүгээрээ Бурхан Израильчуудын эрх болон үүргийг тодорхой болгож өгсөн юм. Хожим нь Давид болон Соломон, мөн Израилийн болон Иудейн цөөн хэдэн хаан Бурханы хаанчлалыг өөр үндэстнүүдийн дунд тэлэхэд

Бурхан хариуд нь тэднийг шийтгэсэн байдаг. Бурхан Ассири болон Вавилоны хорон муу эзэнт гүрнүүдийг Израилийн эсрэг босгон, тэднийг бут цохиулж байсан юм. Олон удаагийн дайралтад Давидын гэр устаж, Бурханы сүм нурж, Иерусалим хот сүйрсэн бөгөөд ихэнх Израильчууд олзлогдон цөллөгт явсан. Амлагдсан газар үнс нурам болж үлдэв. Ийнхүү Хуучин Гэрээний төгсгөл гэхэд Бурханы хаанчлалын олсон амжилт бүр устаж үгүй болдог. Шинэ Гэрээний цаг үе хүртэл Израиль дахь Бурханы хаанчлал нь харь үндэстнүүд болон тэдний 500 гаруй жил үйлчилсэн сатаны шүтээнүүдийн дарлал дор зовж шаналж байсан.

Харамсалтай нь, орчин үеийн Христитгэгчид дээрх нөхцөл байдлыг сайн мэддэггүй учир Хуучин Гэрээний үеийн Бурханы хаанчлалын уналт Шинэ Гэрээний теологид хэрхэн нөлөөлснийг гүйцэт анзаарч ойлгодоггүй. Гэтэл Израилчууд харь үндэстний дарлал дор байсан нь нэгдүгээр зууны Израильчууд, тэр дундаа Есүсийн дагалдагч нарын оюун санаанд хүндээр тусаж байсан юм. Цөллөг Бурханы харагдах хаанчлалын төгсгөл байсан гэж үү?, Бурханы хаанчлалд найдвар өгөх Сайнмэдээ байдаг уу? хэмээн нэгдүгээр зууны үед Иудейчүүд гайхширч байлаа. Энэ нөхцөл байдал Шинэ Гэрээний бичээчдийг Бурханы хаанчлал дуусаагүй гэдэгт итгэлтэй байхад нөлөөлсөн. Тэд итгэл найдвар алдраагүй. Цөллөгийн цаг үе дуусна гэсэн Сайнмэдээг Назарын Есүс тунхагласан юм. Мөн Израил бүтэлгүйтсэн хэдий ч Бурханы ялгуулсан хаанчлал Христийн дотор дэлхий даяар түгэх болно.

Бүгдээрээ Бурханы хаанчлалын тухай ойлголтын түүхэн ач холбогдлыг Израилын Уналттай хамааруулж авч үзлээ. Одоо цөллөгийн дараах Бурханы хаанчлалын төлөөх итгэл найдварын тухай ярилцахад бэлэн боллоо.

Израилийн найдвар

Хуучин Гэрээнд Бурхан Израильчуудад хандан эш үзүүлэгч нараараа дамжуулан тэдний итгэмжгүй зангаас нь болж тэдэнд ялагдал болон цөллөг удахгүй ирнэ гэдгийг анхааруулж байсан. Гэвч Бурхан энэрэл хайрынхаа дагуу цөллөгт байгаа тэдэнд агуу ялалтын төлөө гэмээсээ эргэхийг эш үзүүлэгч нараараа дамжуулан уриалсан байдаг. Эдгээр эш үзүүлэгчүүд олон талтай байсан хэдий ч ерөнхийдөө Бурхан дайснуудыг нь бут цохиж, Өөрийн ард түмнээ дэлхийг эзэлсэн сүр жавхлант их хаанчлалынхаа ивээл ерөөлд хүргэнэ гэж Израиль итгэж найдаж байлаа.

Хуучин Гэрээний эш үзүүлэгчүүдэд ийм итгэл найдвар маш олон бий. Гэхдээ бидэнд хангалттай цаг байхгүй тул Исаиа 52-р бүлэгт байдаг олны сайн мэдэх эш үзүүлэгчээс хоёр эшлэлийг авч үзье. Эхлээд Исаиа 52:7-р эшлэлийг уншицгаая. Энд:

“Амар тайвныг сонордуулж, Сайн сайхныг мэдээлж Авралыг сонсгож,
“Чиний Бурхан хаанчлах нь ээ” гэж Сионд өгүүлэх Сайнмэдээ
авчрагчийн хөл Уулсын дээр юутай үзэсгэлэнтэй?” гэжээ (Исаиа 52:7).

Энэ эшлэлд Бурханы хаанчлалын ялалтын Сайнмэдээний тухай ил тодоор дурдсан байдаг учир бидний хувьд ч чухал юм. Мөн Исаиа 40:9 дээр Исаиагийн

төстэй утгатай зүйл хэлсэн байдаг тул энэ эшлэл хоёр бараг л адилхан гэж болно. Энэ хоёр эшлэлийг өргөн утгаар нь авч үзвэл “Сайнмэдээ” бол Бурханы хаанчлалын дахин давтагдашгүй ялалт болон түүний дараах Израилийн цөллөгийн төгсгөлийн тухай юм гэдгийг тодорхойлсон байдаг. Итгэл найдвараар дүүрэн энэ зөгнөлүүд нэгдүгээр зуунд амьдарч байсан ихэнх Иудейчүүдийн теологийн үзэл бодолд ихээхэн нөлөөлсөн нь гарцаагүй юм. Мөн Шинэ Гэрээний теологид ч нөлөөлсөн нь гайхах зүйлгүй билээ.

Хуучин Гэрээний хүүрнэлүүдэд бараг бүхэлдээ цөллөгийн тухай сэдэв давамгайлсан байдаг. Адам Ева хоёр болон Еден цэцэрлэгийн тухай ч эргэн сөхсөн байдаг бөгөөд Израилийн түүхийн нэгэн хэсэг болгосон байна. Тиймээс Хуучин Гэрээний хүүрнэлийн ихэнх хэсгийг бүрдүүлдэг энэ төрлийн таагүй үйл явдлууд цөллөгийн дараах итгэл найдварыг өөрийн эрхгүй эрж хайхад хүргэж байсан биз. Тэгэхээр ойрын ирээдүйг зөгнөсөн зөгнөлүүд их бий. Ялангуяа Исаиа номонд Бурхан Өөрийн ард түмнийг сэргээнэ гээд л. Гэхдээ эдгээр зөгнөлүүдийг бүтээлийн үеийн түүхтэй холбож харвал Израилчууд газар нутгаа эргүүлж авсан ч эхлэл болон түүнээс жаахан хойно үүссэн гол гажуудлыг засахад хангалтгүй нь тодорхой...Тиймээс Хуучин Гэрээний эш үзүүлэгч нар ямар нэгэн онцгой хаан Израилийг даруй чөлөөлөхийг хүсэж байсан нь аргагүй биз. Гэвч үүний зэрэгцээ тэд Бурханы ард түмний жинхэнэ дээд төлөөлөгч жинхэнэ чөлөөлөлтийг авчраасай гэж бас хүсэж байсан юм.

— Др. Шон МкДонау

Исаиа 52:7-р эшлэлийг анхааралтай судлах юм бол Бурханы хаанчлалын ялалтын төлөөх Израилийн итгэл найдвартай холбоотой дөрвөн зүйлийг онцолсон байдаг.

Эхнийх нь, Сайнмэдээ авчрагч нь Сионд “авралыг сонсгож” бас “сайн сайхныг мэдээлнэ” гэж Исаиа хэлсэн. Энэ хоёр үг хоёулаа Еврей хэлний *basar* гэдэг үг бөгөөд Септуагинтэд *евангелизо* гэж орчуулагдсан байдаг. Яг энэ үгийг Шинэ Гэрээнд Христийн доторх Бурханы Хаанчлалын ялалтын тухай, Сайнмэдээний тухай илэрхийлэхдээ ашигласан байдгийг бид өмнө нь харсан.

Хоёрдугаарт, Исаиа 52:7-р эшлэлийг Ром 10:15-р эшлэлд эш татсан байдаг. Тэр эшлэлд Христитгэлийн сургаал номлол нь Израилийн цөллөг дуусах үед сайн мэдээг зарлах тэр сайн мэдээ авчрагчийн тухай Исаиагийн зөгнөлийг биелүүлсэн гэж Паул тайлбарласан байдаг.

Гуравдугаарт, Сайнмэдээ бол “амар тайван” болон “аврал”-ын тухай тунхаглал юм гэдгийг зөгнөсөн. Ефес 6:15-р эшлэлд Паул хэлэхдээ Христитгэлийн “амар тайвны Сайнмэдээ” гэж эш татсан бол Ефес 1:13-р эшлэлд тэрээр “авралын Сайнмэдээ” гэж хэлсэн байдаг.

Дөрөвдүгээрт, энэ эшлэлийн сүүлийн мөрөнд Сайнмэдээг дүгнэн “Чиний Бурхан хаанчилна!” гэж тунхагласан байдаг. Яг энэ үгнээс үндэслэн Есүс болон Шинэ Гэрээний бичээчид “хаанчлалын Сайнмэдээ” эсвэл – “Бурханы” хаанчлал гэж олон удаа эш татан хэлсэн байдаг.

За бүгдээрээ Исаиа 52:7-р эшлэлд Исаиа Израилийн итгэл найдвар ирэх тухай хэрхэн зөгнөснийг үзлээ. Одоо яг энэхүү бүлгийн 10-р эшлэлийг нь хамтдаа харцгаая. Энд Исаиа Израилийн хүсэж байгаа ялалтын хоёр талыг зөгнөн хэлсэн юм. Эхнийх нь Бурханы дайснууд ялагдах тухай тэр зөгнөн хэлсэн.

Бурханы дайснуудын ялагдлын тухай Исаиа 52:10-р эшлэлийн эхний хэсэгт ил тодоор хэлсэн байдаг. Энэ нь:

ЭЗЭН ариун мутраа Хамаг үндэстний нүдэн дээр ил гаргав.
(Исаиа 52:10).

Бурхан “ариун мутраа ил гаргах” гэсэн нь хүч чадалтай мутраараа дайнд дайснуудаа бут цохино гэсэн утгатай юм.

Хуучин Гэрээг сайн мэдэх хүн бүр Бурхан дайснаа олон удаа ялж байсныг мэднэ. Тэгвэл Бурханы ялалтын тухай зөгнөл юугаараа тийм онцгой юм бэ? Энэ эшлэлд Исаиа Бурхан дайснуудаа “хамаг үндэстний өмнө” ялна гэсэн юм. Өөрөөр хэлбэл Израилийн цөллөг дууссаны дараа Бурхан *газар сайгүй байх* бүх дайснаа *бүрэн төгс* ялна гэж Исаиа зөгнөсөн юм. Тэрээр тэдний сүр хүчийг дарж, газар дэлхийгээс зайлуулж, мөнхийн шийтгэл уруу илгээх юм.

Хоёрдугаарт, Исаиа 52:10-р эшлэлийн сүүлийн хэсэгт Бурханы ялалтын үр дүнд Бурханы ард түмэн Түүний хаанчлалын ерөөлөөр аврагдана гэдгийг хэлсэн байдаг. Исаиа 52:10-р эшлэлийг сонсоно уу:

Газрын бүх хязгаар Бурханы маань авралыг үзнэ. (Исаиа 52:10).

Хуучин Гэрээнд Бурхан Өөрийн хүмүүсийг олон удаа аварч байсныг бид мэднэ. Харин энэ эшлэлд Исаиагийн зөгнөсөн авралыг “газрын бүх хязгаар” харж, мэдэх болно гэсэн юм. Бурхан газар сайгүй байх ертөнцийн бүх дайснаа ялах бөгөөд Түүний аврал газрын хязгаар бүрд хүрч, дэлхий дахины хүмүүсийг эцсийн удаа аварна. Эцэс сүүлд нь Бурхан Өөрийн хүмүүсийг баяр хөөр, хайр, зөв шударга, амар тайван, бялхам дүүрэн ба Түүний сүр жавхлант оршихуйд үүрд мөнх баясан цэнгэх тэр хаанчлалдаа оруулах болно.

Бурханы ялалтын энэ хоёр талыг бид хичээлийнхээ сүүлээр илүү нарийвчлан авч үзэх болно. Гэхдээ удахгүй ирэх хаанчлалыг дүрсэлсэн эшлэлүүд үнэндээ Хуучин Гэрээгээр дүүрэн байдаг юм.

Харамсалтай нь 2000 гаруй жилийн хугацаанд уламжлалт Христитгэлийн теологи нь Шинэ Гэрээн дэх Бурханы хаанчлалын тухай ойлголтын ач холбогдлыг бууруулсаар ирсэн юм. Сүм чуулганы түүхийн өөр өөр цаг үеүдэд Христитгэгчид янз бүрийн асуудалд теологийн олон янзын үзэл санааг онцлон тэмдэглэж ирсэн байдаг. Гэхдээ Шинэ Гэрээ бичигдэж байх үед Бурханы хаанчлал ялагдсан байдалтай байсан нь Есүсийн дагалдагч нарын оюун санаанд маш хүнд тусаж байсан гэдгийг

санах хэрэгтэй. Тэдний хувьд Бурханы хаанчлал нь Есүсийн дотор хосгүй ялалтад хүрнэ гэдэг итгэлээс илүү чухал зүйл байгаагүй. Энэ шалтгааны улмаас Шинэ Гэрээний теологи Бурханы хаанчлалын Сайнмэдээн дээр үндэслэн хэлбэржсэн байдаг.

Бурханы хаанчлалын тухай энэхүү хичээлээрээ бид Шинэ Гэрээний теологи дахь хаанчлалын Сайнмэдээний тухай сэдвийг танилцууллаа. Одоо бүгдээрээ дараагийн гол сэдэв буюу ирж буй хаанчлал нь Шинэ Гэрээний теологийг хэрхэн хэлбэржүүлсэн тухай авч үзье.

ИРЖ БУЙ ХААНЧЛАЛ

Ямар нэг зүйл удахгүй болох гэж байгаад баттай итгэлтэй байх тохиолдол бидний амьдралд олон байдаг. Гэвч заримдаа бидний хүлээж байсан зүйл биелэх үед төсөөлснөөс өөр байх нь бий. Шинэ Гэрээг бичсэн хүмүүсийн хувьд яг л ийм нөхцөл байдалд ороод байсан юм. Нэгдүгээр зуунд амьдарч байсан Иудейчүүдийн олонх нь Бурханы хаанчлал ирж, ялалтыг авчрах талаар бат итгэн хүлээж байлаа. Харин Есүсийн анхны дагалдагч нар тэдний төсөөлж байсан зүйл болохгүй гэдгийг аажимдаа ойлгосон юм. Тиймээс Шинэ Гэрээний теологийн гол зорилго нь хаанчлалын ялалт чухам хэрхэн ирэхийг олон янзаар тайлбарлахад чиглэсэн гэлтэй байдаг.

Хаанчлалын ирэлт нь Шинэ Гэрээний теологид хэрхэн нөлөөлснийг ойлгохын тулд бид эхлээд Бурханы хаанчлал хэрхэн ирэх талаар ямар хүлээлтүүд байсныг авч үзэх хэрэгтэй. Харин дараа нь бидний хэлж заншсанаар хаанчлалын гурван үет ялалтын талаарх Шинэ Гэрээний үзэл санааг авч үзэх болно. Тэгвэл эхлээд ирэх хаанчлалын талаарх хүлээлтүүдийн тухай ярилцъя.

ХҮЛЭЭЛТҮҮД

Нэгдүгээр зуунд бүх Иудейчүүд болон өвөг дээдсийнхээ итгэл үнэмшлийг төдийлөн дагадаггүй Иудейчүүд ч Бурханы хаанчлалын ялалт ирээсэй хэмээн хүсэн хүлээж байлаа. Бурхан бүх дайсныг нь бут цохиж хаанчлалынхаа сайн сайханд оруулна гэж тэд итгэж найдаж байв. Есүсийн дагалдагч нар ч бас ийм бодолтой байсан. Гэтэл Бурханы хаанчлалын ялалт хэзээ бас хэрхэн ирэх нь тэдний хүсэн хүлээж байснаас тэс өөр байсан юм.

Израилийн багш нар болон ахлагчид Бурханы хаанчлалын эцсийн ялалтын тухай заахдаа Хуучин Гэрээнд “эцсийн өдрүүд” болон “Эзэний өдөр” гэсэн санаануудыг түгээмэл ашигласан байдаг. Гэхдээ тэд мөн түүхийн хоёр агуу их үеийн тухай өгүүлсэн байдаг. Багш нар ихэвчлэн гэм нүгэл, зовлон ба үхэл бүхий одоо цаг үеийг “энэ үе” буюу Еврей хэлээр *олам хазе* гэсэн. Мөн цөллөгийн дараах зөвт байдал, хайр, баяр хөөр бүхий ирээдүйн цаг үеийг “ирэх үе” буюу Еврей хэлээр *олам хаба* гэсэн байна.

Тэд “энэ үе”-ийн хамгийн доройтлын цэгтээ хүрсэн үе бол амлагдсан нутгаасаа цөлөгдөн хараагдсан үе юм хэмээн зааж байв. Мэдээж Бурхан энэ үеийг захирч байсан ба Өөрийн хаанчлалыг үеэс үед онцгой арга замуудаар илчлэн харуулсаар ирсэн. Гэвч нэгдүгээр зуунд амьдарч байсан Бурханы хүмүүс олон зуун жилийн

турш Бурханы хаанчлалын ерөөлөөс таслагдан, дарлал зовлон амсаад байсан юм. Тэрхүү “ирэх үе” болоход Бурханы бүх дайсан ялагдаж, газар дэлхийгээс арчигдана гэсэн хүлээлт бүгдэд байв. Тэгээд Бурханы хүмүүс Бурханы дэлхий даяарх хаанчлалын хэмжээлшгүй ерөөлийг хүртэх болно.



Библийн утга зохиол болон Библийн тухай яриа хэлэлцүүлгүүдээс бид заримдаа “энэ үе” болон “ирэх үе” гэсэн нэр томъёог олж хардаг шүү дээ. Эдгээр хэллэгүүд дараах утгатай байна. “Энэ үе” гэдэг бол гэм нүглийн Уналтаас хойших үе буюу хүн төрөлхтний одоо амьдарч буй эринийг ба цаг хугацааг хэлнэ. Энэ бол гэм нүгэлд унасан дэлхий дээрх амьдрал юм. Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийн хүлээж байсан “ирэх үе” бол Бурхан ямар нэгэн байдлаар диваажинг дахин байгуулах цаг үе юм. Тэр үед шинэ тэнгэр, шинэ газар бий болж хүмүүний чулуун зүрх үгүй болно. Бид бүгд Бурханы хүслийг бүрэн төгс дагаж, биелүүлнэ. Хүн төрөлхтөн байтугай адгуус амьтдын дунд ч хүчирхийлэл үгүй болно.

— Др. Экхад Ж. Шнабел

Нэгдүгээр зуунд Иудейн бүлэглэлүүд нь “энэ үе”-ээс “ирэх үе” уруу шилжихээс өмнө түүхэнд чухам юу болох талаар өөр өөр үзэл бодолтой байсан. Гэхдээ тэдний олонх нь ялагдлын энэ үеэс Бурханы ялалт бүхий хаанчлал уруу шилжихэд аймшигт дайн болно гэдэг дээр санал нэгдэж байв. Давидын хаан ширээг залгамжлагч Мессиа нь тэнгэр элч нар болон Бурханы итгэмжит хүмүүсийг удирдан, Бурханы дайсан болсон хүмүүс болон сүнслэг хүчнүүдийг ялах болно хэмээн тэд итгэдэг байв.

Бурхан зөвхөн Өөрийн дайсан болсон хүмүүсийг төдийгүй харин сүнслэг дайснуудаа ч ялна гэдэг итгэл үнэмшлийг Хуучин Гэрээний бүхий л Бичвэрүүд дэмждэг. Жишээ нь, Гэтлэл 12:12 дээр Бурхан зөвхөн Египетчүүдийг төдийгүй тэдний бурхдыг ч ялах тухай өгүүлсэн байдаг. Мөн 1 Самуел 5:1-12 дээр Бурхан

Филистчүүдийн эсрэг дайтаж, тэдний Дагон хэмээх хуурамч шүтээнийг нь бут цохисон тухай бий. Исаиа 21:9 дээр Вавилоны ялагдлыг тэдний бурхдыг нь устгасантай холбосон нь мөн ийм учиртай.

Хуучин Гэрээний номууд болох Хаггай 2:6-9, Зехариа 9–12 болон Езекиел 38–39 зэрэг Иудейн апокалиптик буюу эцсийн цаг үеийн тухай зохиолуудыг Мессиа Бурханы их цэргийг удирдан бүх үндэстэн болон хорон муу сүнснүүдийг хаанчлан захирах агуу тэнгэрийн дайны тухай зөгнөл гэж үздэг. Ийнхүү Мессиа Бурханы бүх дайсныг ялж, Бурханы хүмүүсийг авран, бүх дэлхийн сүр жавхлант хаанчлалдаа оруулах юм.

Нөгөө талаараа Иудейн энэ итгэл үнэмшил түгээмэл байсны улмаас Есүсийн дагалдагч нар бас Бурханы хаанчлалыг өөрөөр хүлээж байлаа. Тухайн цаг үеийн ихэнх хүмүүсийн нэгэн адил Шинэ Гэрээний бичээчид ч түүхийг хоёр агуу үед хуваана гэж итгэж байв. Мессиа Бурханы хүн ба сүнслэг дайснуудыг ялж, Өөрийн хүмүүсийг чөлөөлж, “энэ үе”-ээс “ирэх үе”-ийн ерөөлд аваачна гэж итгэж байлаа. Гэвч Есүсийн дагалдагчид энэ үеэс ирэх үед шилжих арга замын хувьд тухайн үеийнхээ ихэнх Иудейчүүдийн итгэж хүлээж байснаас ялгарч байв.

Юуны түрүүнд Шинэ Гэрээний бичээчид *Есүс* бол Давидын сонгогдсон удам, дэлхий дахинд Бурханы хаанчлалын эцсийн ялалтыг авчрах амлагдсан Мессиа гэдэгт бат итгэж байснаараа Иудейчүүдээс ялгаатай байв. Есүсийг Мессиа гэж тууштай итгэсэн нь тэдний Шинэ Гэрээний номуудад бичсэн бүхий л зүйлд гүн нөлөөлсөн.

Есүсийг Мессиагийн хаан мөн гэдэгт хэр их итгэж байсныг бид Шинэ Гэрээн дэх Түүнд өгсөн эрхэм дээд нэрсээс нь харж болно. Жишээ нь, Шинэ Гэрээнд Есүсийг “Христ” хэмээн 529 удаа нэрлэсэн байдаг. Грек хэлний *Христос* гэдэг үг нь Хуучин Гэрээний Еврей хэлний *Мешиах* буюу бидний хэлдгээр Мессиа гэдэг үг юм. Энэ үг нь утгаа “тослогдсон нэгэн” гэсэн энгийн утгатай. Хуучин Гэрээний цаг үед Израильд эш үзүүлэгч, тахилч нар болон хаадыг тусгайлан тосолдог байсан. Харин Шинэ Гэрээний цаг үе ирэхэд “Тослогдсон Нэгэн” эсвэл “Мессиа” гэдэг үг нь ирэх үеийг авчрах агуу Давид хааны удам гэсэнтэй ижил утгатай болсон байв.

Шинэ Гэрээнд Есүст өгсөн хоёр дахь эрхэм дээд нэр бол “Бурханы Хүү” юм. Үүнийг заримдаа “Хүү” эсвэл “Хамгийн дээд Нэгэний Хүү” зэргээр мөн хэлдэг. Энэ нь Шинэ Гэрээнд нийт 118 удаа гардаг. Энэ нэр томьёо нь Есүс бол Израилийн жинхэнэ Хаан гэдгийг тодорхойлдог. Тэгвэл Иохан 1:49 дээр Натанаел Есүст юу гэж хэлснийг харцгаая. Энэ нь:

“Та бол Бурханы Хүү. Та бол Израилийн Хаан” гэжээ (Иохан 1:49).

Матай 16:16 дээр Петр Есүст итгэх итгэлээ ийнхүү илэрхийлсэн байдаг. Тэрээр:

“Та бол Христ, амьд Бурханы Хүү” гэжээ (Матай 16:16).

Петрийн ийнхүү хэлсэн нь Есүсийг нэрлэсэн гурав дахь эрхэм дээд нэр болох “Давидын хүү” гэсэнтэй адил юм. Энэ нэр нь Матай, Марк, Лукийн Сайнмэдээнд дор хаяж 20 удаа гардаг. Энд Есүсийг Давидын хаан ширээний зүй ёсны бөгөөд Бурханы томилсон залгамжлагч хэмээжээ.

Жишээ нь, Лук 1:32-33 дээр Габриел тэнгэр элч Мариад мэдээ дуулгахдаа ийнхүү хэлжээ. Энд:

“[Есүс] Тэр Хүү аугаа Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана. Эзэн Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно. Тэр Иаковын гэрийг үүрд хаанчлах бөгөөд хаанчлалд нь төгсгөл гэж үгүй” гэжээ (Лук 1:32-33).

Габриел энд Есүсийг “Хамгийн Дээд Нэгэний Хүү” гэсэн эрхэм дээд нэрээр дуудаад, “өвөг Давидынхаа хаан ширээнд” сууна гэж хэлсэн. Лук Есүсийг “...үүрд хаанчлах бөгөөд Түүний хаанчлалд төгсгөл гэж байхгүй” гэжээ. Хамгийн Дээд Нэгэний Хүү болох Есүс бол Бурханы хаанчлалын эцсийн бөгөөд үл төгсөх ялалтыг авчрах Нэгэн юм.

Эдгээр эшлэлүүдээс Есүс бол Бурханы хаанчлалыг газар дэлхийд бүрэн төгс авчрах Мессиа мөн гэсэн Шинэ Гэрээний теологийн чухал ач холбогдол бүхий сургаал урган гарсан..

Хоёрдугаарт, Есүсийн анхны дагалдагч нар Түүнийг энэ үеэс ирэх үе уруу хэнийх нь ч санаанд оромгүй байдлаар шилжүүлнэ гэж итгэцгээж байсан юм.

Матай 13:31-32 дээр Есүс Бурханы хаанчлалын талаарх хүлээлтүүдийг хэрхэн өөрчилснийг сонсоцгооё. Энд:

“Есүс тэдэнд [цугласан хүмүүст] өөр нэгэн сургаалт зүйрлэл хэлэхдээ —Тэнгэрийн хаанчлал нь хүний авч, цэцэрлэгтээ суулгасан гичний үр мэт юм. Энэ нь бусад бүх үрээс жижигхэн боловч ургахдаа ургамал ногооноос илүү томорч, мод болдог тул тэнгэрийн шувууд ирж, мөчрүүд дээр нь үүрээ засдаг юм гэлээ” гэжээ (Матай 13:31-32).

Энэ сургаалт зүйрлэлд Бурханы хаанчлалын ялалт жижигхэн зүйлээс эхэлнэ гэж Есүс заасан. Яг л “гичний үр мэт,” ургаж боловсорсны дараа хурааж авах цаг нь *хожим* ирэхтэй адилхан.

Орчин үеийн теологичид Бурханы Мессиагаар холбоотой хаанчлал хэрхэн ирэх талаарх Есүсийн үзлийг “ирэх юмсын эхлэл” буюу эхлэл тавьсан Эсхатологи гэж нэрлэдэг. Энэ үг хэллэгийн гол санаа нь Мессиа газар дэлхий дээр ажлаа аль хэдий хийсэн боловч *эцсийн* ялалт хараахан ирээгүй байгаа гэсэн утгатай. Тэд заримдаа үүнийг “аль хэдийн гэхдээ арай болоогүй” гэж хэлэх нь бий. Өөрөөр хэлбэл ирж буй Бурханы хаанчлалын ялалт *аль хэдийн* ирсэн боловч *хараахан* бүрэн төгс болоогүй байна гэсэн үг юм. Бурханы ирж буй хаанчлалын ялалтын талаарх энэ үзэл Шинэ Гэрээний теологид тоолж баршгүй ойлголтуудыг бий болгодог билээ.




Эхлэлийг тавьсан эсхатологи

Есүс Бурханы хаанчлалын тухай зарлан тунхаглах үед урган гарсан томоохон асуултуудын нэг бол Бурханы хаанчлал нь одоо бодитоор бий юу? гэдэг асуулт юм. Хаанчлал нь Есүсийн үг ба үйл хэргээр хэдийнэ биелсэн үү? Эсвэл ирээдүйд биелэх юм уу? Тиймээс судлаачид “Бурханы хаанчлалын эхлэл тавигдсан” гэж үздэг. Энэхүү “эхлэл тавигдсан” гэдэг нь одоо ба ирээдүйг зэрэг хамаардаг. Есүс хаанчлалыг зарлан тунхагласан. Хаанчлал Түүний үг ба үйл хэргээр буюу онцгойлон Түүний загалмай дээрх үхэл болон амиллаар нь дамжин ирж буй юм. Тиймээс хаанчлалын эхлэл хэдийн тавигдсан. Гэхдээ энэ үйл хэрэг хараахан бүрэн төгс дуусаагүй байна. Хаанчлал энэ газар дэлхийд бүрэн төгс болох үед бид алдаршуулагдсан биенийг хүлээн аваад, Бурхантай үүрд хамт байна байх болно. Тиймээс өнөөдөр бид энэ хоёр цаг хугацааны дунд амьдарч байгаа гэсэн үг юм. Бид хаанчлалын эхлэл тавигдсанаас хойш бүрэн төгс байгуулагдах тэрхүү хоёр үеийн заагт амьдарч байна. Бид энэ л унасан дэлхийд, энэ л махан биедээ амьдарсаар байгаа хэдий ч Христ Эцэгийнхээ баруун гар талд залран хаанчилж байгаа тул хаанчлал ирсэн гэсэн үг билээ. Тэрээр мөн бидний зүрх сэтгэлд хаанчилж байна. Тиймээс хаанчлал “аль хэдийн” ирчихсэн. Гэхдээ ирээдүйд бүрэн төгс болох тул мөн “хараахан ирээгүй” байна.

— Др. Марк Л. Страус

Ерөнхийдөө энэ нь Бурханы хаанчлалын тухай Шинэ Гэрээний үзлийг гурван үет ялалт гэж харахад тусалдаг. Эхнийх нь, *эхлэл тавигдсан үед* Бурхан Есүсийн амьдрал, үхэл, амилал, тэнгэр өөд одсоноор болон анхны зууны элч ба эш үзүүлэгчдийн суурь болсон үйлчлэлээр дамжуулан хаанчлалынхаа ялалтыг хэдийнээ эхлүүлсэн. Үүний дараагаар *үргэлжлэх үед* Есүс тэнгэр дэх хаан сэнтийнээсээ Бурханы хаанчлалын ялалтыг ахиулсаар байгаа. Мөн Есүс сүм чуулганы түүхийн туршид хаанчлалаа үргэлжлүүлсээр байх болно. Тэгээд эцэст нь, Есүс сүр жавхлантайгаар эргэн ирэх үед хаанчлал нь *бүрэн төгс ялах үе* ирнэ. Бурханы



Бурханы хаанчлалын ялалт нь гурван үетэй

хаанчлалын эцсийн ялалт ирэх үед ёр муу бүхэн устгагдаж, Бурханы сүр жавхлант хаанчлал дэлхийн өнцөг булан бүрд хүрэх юм.


Шинэ Гэрээг бичсэн хүмүүс олон янзын теологийн асуудлуудыг тайлбарлахад ихээхэн чармайлт гаргаснаар Есүсийн Мессиагийн ажлын эдгээр гурван үе шатыг голчлон тайлбарласан.

Хаанчлалын ирэлтийн талаарх анхны зууны Есүсийн дагалдагч нарын хүлээлт хэрхэн өөрчлөгдсөн тухай бид ярилцлаа. Одоо бүгдээрээ Шинэ Гэрээний теологи дахь Бурханы хаанчлалын гурван үет ялалтын ач холбогдлыг авч үзье.

ГУРВАН ҮЕТ ЯЛАЛТ

Бурханы хаанчлалын ялалт нь Есүсийн мессиагийн ажлын буюу эхлэл үе, үргэлжлэх үе, бүрэн төгс болгох үеэр дамжин ирнэ гэсэн нь анхны сүм чуулганд олон асуултыг бий болгосон. Есүс хэдийнээ юу хийсэн бэ? Тэрээр чуулганы түүхэнд юуг хийх байсан бэ? Тэр эргэж ирэхдээ юу хийх вэ? Эдгээр асуултууд нь нэгдүгээр

зуунд Шинэ Гэрээний теологийг гүн гүнзгий хэлбэржүүлэхэд чухал байсан. Бурханы дайснууд ялагдаж, Бурханы хүмүүсийг аврах ажил Христийн анхны ирэлтээр аль хэдийн эхэлсэн гэдгийг Шинэ Гэрээний бичээчид хичээнгүйлэн тайлбарласан байдаг. Энэ үйл явдал сүм чуулганы түүхийн туршид үргэлжлэх бөгөөд Христ дахин сүр жавхлантайгаар ирэх үед бүрэн төгс болох юм.



Хаанчлалын Гурван үе


Уг ялалтын гурван үе шат нь Шинэ Гэрээний теологийг хэрхэн хэлбэржүүлснийг ярихад хангалттай цаг бидэнд байна. Гэхдээ бид хоёр чиглэлийг авч үзэх болно. Эхнийх нь, хаанчлалын гурван үе шатын явцад Бурханы дайснууд хэрхэн ялагдах тухай Шинэ Гэрээнд юу гэж заадгийг товч үзье. Дараа нь бид энэ гурван үе шатын туршид Бурханы хүмүүс хэрхэн аврагдах тухай авч үзэх болно. Тиймээс Бурханы дайснууд хэрхэн ялагдах талаар одоо ярилцъя.

Дайсны Ялагдал

Мессиа нь Өөрийн дайсан болсон хүмүүс болон сүнслэг хүчийг ялна гэдэгт Христжд үл итгэгч Иудейчүүд ч итгэдэг байсан. Шинэ Гэрээний бичээчид ч үүнд итгэж байв. Гэхдээ тэд Есүс хаанчлалынхаа гурван үе шат бүрд тохирсон арга замаар ялна гэдгийг ойлгосон юм. Шинэ Гэрээний теологид Есүсийн хаанчлалынхаа суурийг тавьсан стратеги хоёр талтай байсан гэдгийг онцолж үздэг. Нэг талаар Есүс Бурханы эсрэг сүнслэг дайснуудын дээр Бурханы шүүлтийг авчирсан. Тэрээр үйлчлэлийнхээ туршид ёрын муу сүнснүүдийн хүч чадлыг үгүй болгож, эрх мэдлийг нь үгүйсгэж байсан. Харин нөгөө талаар Тэрээр Бурханы дайсан болсон хүмүүст Бурханы хайр өршөөлийг боломжтой болгож өгсөн юм. Христийн хүмүүсийн төлөөх

хайр өршөөл тэдэнд олон ерөөлийг авчирсан. Мөн энэ нь ёрын сүнснүүдээс тэдний боол байсан хүмүүсийг нь булааснаар тэднийг бут цохин ялах нь дамжиггүй.

Матай 12:28-29 дээр Есүс Өөрийн энэхүү төлөвлөгөөг тайлбарласан байдаг. Энэ нь:



“Гэвч Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы хаанчлал та нарт ирчхээд байна. Бяртай эрийг эхлээд хүлэхгүй бол хэрхэн гэрт нь орж, эд хөрөнгийг нь дээрэмдэж чадах билээ? Тэгж байж л гэрийг нь дээрэмдэнэ шүү дээ.” гэжээ (Матай 12:28-29).

Есүс ирж чөтгөрүүдийг хүлсэн буюу “гэрийг нь дээрэмдэхийн” тулд “бяртай эрийг хүлсэн”. Өөрөөр хэлбэл, Есүс чөтгөрүүдийг хөөж, чөтгөрийн хүлээс дор байсан хүмүүсийг чөлөөлсөн юм.

Иохан 12:31-32 дээр Есүсийн хэлсэн үгнээс бид бас энэхүү хоёр талт стратегийг харж болно. Энд:

“Одоо энэ ертөнц шүүгдэх гэж байна. Одоо энэ ертөнцийн захирагч зайлуулагдах болно. Би газраас өргөгдвөл бүх хүнийг Өөртөө татна гэж айлдлаа” гэжээ (Иохан 12:31-32).

Хаанчлалын эхлэлийг тавигдах үед Есүс бузар сүнснүүд руу буюу “энэ ертөнцийн захирагч” болох Сатан уруу дахин нэг удаа дайрсан. Тэр түүнийг зайлуулж, хүчгүй болгосон. Есүс сатаныг ийнхүү бут цохихын зэрэгцээ хүн төрөлхтөнд авралыг өгсөн юм.

Ялагч Христ буюу *Христос Викторын* тухай үзэл нь хэрхэн бидний гэмийн төлөө үхэж, өр төлөөсийг төлсөн гэдэг Христийн талаарх ойлголттой нийцэж, холбоотой байдаг юм бэ? гэж хүмүүс заримдаа гайхдаг ... Иоханы Сайнмэдээнд цөлд могой өргөгдсөнтэй адил Хүний Хүү өргөгдөх тухай Есүс гурав дахь удаагаа ярьсан байдаг. Энэ нь Иохан 12-р бүлэгт бий. Тэрээр энэхүү өргөгдөх тухайгаа “энэ ертөнцийн захирагч зайлуулагдах болно” гэсэн мэдэгдэлтэй холбосон байдаг. Есүс тэр хараагдсан могойн оронд Өөрийгөө тавьж, үхлийг Өөрийнхөө дотор шийтгэн устгахын тулд үхсэн юм. *Христос Викторын* хувиар Түүний хийсэн анхны үйлс бол загалмай дээр өргөгдөж Өөрийнхөө дотор үхлийг устгах явдал байлаа.

— Рэв. Майкл Ж. Глодо

Бурханы сүнслэг дайснуудыг ялан дийлсэн нь Христийн хаанчлалын эхлэлийг тавих ажлын маш чухал хэсэг байсныг Еврей 2:14-15 зэрэг эшлэлүүдээс харж болно. Шинэ Гэрээг бичсэн хүмүүс Христийн загалмай дээр төлөөс болон амиа өгснийг хоёр талт стратеги талаас нь тайлбарлаж бичсэн байдаг. Есүс үхсэнээр Сатаны хүн төрөлхтнийг захирч байсан хүч үгүй болсон гэдгийг тэд тодорхой бичсэн байдаг. Мөн хүн төрөлхтний гэмийн төлөөс болсноороо Есүс гэм нүгэл болон үхлийн боолчлолд байсан хүмүүсийг чөлөөлсөн юм.

Эдгээр ойлголтуудын талаар Колоссай 2:15 дээр элч Паул хэрхэн бичсэнийг харцгаая. Энд:

“Захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгоод, Тэр [Христ] тэднийг загалмай дээр ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов” гэжээ (Колоссай 2:15).

Есүс загалмай дээр амиа өгч, хүмүүсийг нүглийн хүчнээс чөлөөлөхөд чөтгөрийн хүч болон эрх мэдлүүд нь захирагч байр сууриа алдсан.

Үүний гэрэлд харвал Ефес 4:8 дээрх Христ үхлээс амилж, дээш өргөгдсөнөөрөө Сатаны боол болсон хүмүүсийг олзлон авсан гэснийг уншихдаа гайхах зүйлгүй. Энд:

“Өндөрт дээш гарахдаа, Тэрээр олзоллыг олзолж хүмүүст бэлгүүд өгсөн” гэдэг (Ефес 4:8).

Үүнээс үзвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүс Христэд итгэх үед Тэрээр тэднийг сатаны хаанчлалаас чөлөөлөн авдаг гэжээ.

Бурханы эсрэг сүнслэг дайснуудыг ялах Есүсийн энэхүү стратеги нь Үйлс ном дахь Христийн элч нарын эхлэл суурийг тавих ажилд ч мөн гардаг. Элч нар Есүсийн үлгэр дуурайллыг даган харь үндэстнүүдийн дунд Сайнмэдээг тунхаглаж, чөтгөрүүдийг хөөж, олон хүнийг сатаны боолчлолоос аварсан юм.


Мэдээж сүм чуулганы түүхийн туршид үргэлжилж буй Христийн хаанчлалыг авч үзвэл Христийн дагалдагчид Есүсийн эхлэл үедээ хэрэглэж байсан стратегийг

дагаж байсныг харж болно. Тэд Бурханы дайсан болсон хүмүүсийг ялахаас илүү Бурханы ажилд саад тээг болдог ёрын сүнснүүдэд анхаарлаа хандуулж байсан юм.

Өнөө үед Христитгэгч олон хүн үүнийг ойлгохгүй байгаа. Хэдий тийм ч Шинэ Гэрээний хаанчлалын теологи бидэнд Есүсийн сүм чуулган хүмүүстэй тэмцэлддэггүй, харин сатан болон бузар сүнснүүдтэй тэмцдэг гэдгийг сануулсаар байдаг. Бурханы сүнслэг дайснуудыг ялах нь бидний үүрэг хариуцлага мөн.

Ефес 6:11-12 зэрэг эшлэлүүдээс харахад, Шинэ Гэрээнд бидний бэрхшээл болон асуудлуудыг бузар сүнстэй холбон тайлбарласан нь ийм учиртай. Дараах эшлэлийг уншицгаая. Энд:

“Та нар диаволын заль мэхний эсрэг зогсож чадахын тулд Бурханы өвч зэвсгийг агс. Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ” гэжээ (Ефес 6:11-12).



Үргэлжлэл

Өнөө цагийн Христитгэгчид амьдралд нь тулгарч буй асуудлуудыг хүмүүстэй л ихэвчлэн холбож ойлгодог. Гэтэл бид энэ эшлэлээс сүм чуулганд тулгарч буй гол асуудал бол үнэндээ “бузар сүнс”, “эрх мэдлүүд”, “захирагчид” болон “тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүч” гэдгийг харж болно. Харин Бурханы өвч зэвсгээр өөрсдийгөө зэвсэглэснээр бид Бурханы хаанчлалыг эсэргүүцдэг тэдгээр сүнслэг хүчийг ялж чадах юм.

Энэхүү эшлэлд Христийн сүм чуулган түүхийн туршид Христийн хаанчлалын нэг чухал тал болох сүнслэг тэмцлийг онцолсон нь гайхмаар зүйл биш юм. Сатан болон бузар сүнснүүдтэй хийх байнгын тэмцлийн тухай Ефес 4:27, 1 Тимот 3:7, 2 Тимот 2:26, Иаков 4:7, 1 Петр 5:8, 1 Иохан 3:8 болон Иуда 9 зэрэг бусад олон эшлэлүүдэд дурдсан байдаг. Мөн үүний зэрэгцээ бид Бурханы өршөөл хайрыг түүнийг эсэргүүцэгч хүмүүст үзүүлэх ёстойг 2 Коринт 5:20 дээр сануулсан байдаг. Энэ нь:

“Иймээс бид Христийн төлөөх элчин сайд юм. Бурхан биднээр дамжуулан ятгаж байгаачлан Христийн төлөө та нараас бид гуйя. Бурхантай эвлэрцгээ” гэдэг (2 Коринт 5:20).

Паулын үлгэр жишээг даган бид “Христийн элчин сайд” болох Бурханы хаанчлалыг төлөөлөгчийн хувьд Бурханыг Түүний дайсан болсон хүмүүстэй нь эвлэрүүлэх замаар сүнслэг дайснуудыг нь ялсаар байх болно.

Шинэ Гэрээний теологийн салшгүй нэг хэсэг нь Христийн хаанчлал бүрэн төгс болсноор Бурханы дайснуудыг ялах тухай ойлголт байдаг. Харин хаанчлал бүрэн төгс болох тэр үед Есүсийн стратегид маш том өөрчлөлт гарах болно гэдгийг

ойлгох нь чухал. Христ эргэн ирэх тэр үедээ Бурханыг эсэргүүцдэг хүмүүст дахин өршөөл үзүүлэхгүй. Харин Тэрээр тулааныг удирдан, Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болон сүнслэг дайснуудаа бүрэн төгс ялж, эцсийн шүүлтээр шүүн, газар дэлхийгээс устгах болно.



Бүрэн төгс

Илчлэл 19:13-15 дээр хаанчлалыг бүрэн төгс бологох тэр үед Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийг хэрхэн бут цохих талаар юу гэж бичсэнийг хамтдаа харцгаая. Энд:

“...Түүний нэрийг “Бурханы Үг” гэдэг ажээ. Цагаан бөгөөд цэвэр, нарийн маалинган хувцас өмссөн, тэнгэрийн дайчид цагаан морьд унан Түүнийг дагаж байв. Түүний амнаас хурц сэлэм гарсан байх агаад түүгээр Тэр үндэстнүүдийг цохих юм” гэжээ (Илчлэл 19:13-15).

Үүний адилаар Христ сүр жавхлантайгаар эргэн ирэх тэр үед бузар сүнснүүд болон Сатаны эцсийн шүүлт болох болно гэдгийг Илчлэл 20:10 дээр тодорхой хэлсэн байдаг. Энэ нь:

“Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна” гэдэг (Илчлэл 20:10).

Мэдээж бид эдгээр асуудлуудын тухай маш товчхон ярьж байгаа. Хэдий тийм боловч та бүхэн Шинэ Гэрээний бичээчид хаанчлалын ялалтыг энэ талаас нь ойлгуулахыг хэчнээн чухалд тооцож байсныг эдгээр жишээнүүдээс харж чадсан байх гэж бодож байна. Тэд хаанчлалын эхлэл үе болон үргэлжлэх үед бузар сүнснүүдийг эсэргүүцэж, харин Бурханы эсрэг хүмүүсийг энэрэл хайраар хайрлах нь ямар чухал болохыг онцгойлон ойлгуулахад санаагаа чилээсэн юм. Мөн тэд Христ эргэн ирэх эцсийн тэр үед Бурханы дайсан болсон хүмүүс болон бузар сүнснүүд бүгд Бурханы эцсийн шүүлтэд орох болно гэжээ. Эдгээрээс харахад Бурханы дайснуудыг ялах нь Шинэ Гэрээний теологийн маш чухал хэсэг гэдэг нь батлагдаж байна.

Хаанчлал нь аль хэдийнээ эхэлсэн бөгөөд бидний дунд байна. Гэхдээ бүрэн төгс болох тэр үеийг хүртэл үргэлжлүүлэн байгуулагдсаар байгаа билээ. Тэгвэл Есүс дайснуудаа аль хэдий ялчихсан уу? гэсэн асуулт гарч ирнэ. Тэгэхээр юуны өмнө, загалмай бол Сатаныг ялсан хамгийн чухал ялалт юм... энэ утгаараа хамгийн чухал тулаандаа ялчихсан гэсэн үг. Жишээ нь, Илчлэл 12-р бүлэгт ариун хүмүүс ах дүүсийг нь буруутгагч нэгэнд хариу өгч, түүнийг Хурганы цусаар ялдаг. Тэд Сатаныг ялсныг энэхүү Ичлэл 12-р бүлэгт зүйрлэлээр тайлбарласан байдаг ба тэд түүнийг Хурганы цусаар ялдаг. Тиймээс тулаанд аль хэдийн ялсан

гэсэн үг. Гэвч яг Гитлертэй адил, тэр Дэлхийн II дайнд ялагдсан гэдгээ мэдэж байсан ч тулалдахаа болиогүй шүү дээ. Тэр уур хилэндээ шатаж өөрийнх нь цаг дуусаж байгааг мэдэж байсан. Сатан бас яг ийм байдалд байгаа юм. Тиймээс Сатан бол одоо бүр эрчтэйгээр хорон муу зүйлээ хийж байгаа. Сайнмэдээ тараах ажил өргөжин тэлж, хүмүүс итгэлд ирэх тусам, хүмүүсийн амьдралд, сүм чуулгануудад болон газар бүрд зөвт байдал тогтох бүрд Сатан ба харанхуйн хүчнийхэн ажлаа эрчимтэй хийсээр байдаг. Бүрэн төгс ялалтыг авчрах эцсийн тэр тулааны дараа энэ дэлхий дээр Бурхан ба Христийн хаанчлал бүрэн тогтож, үүрд мөнх хаанчлах болно... Хамгийн гол нь тэрхүү ялалтад хүрэх замаа тогтоосон тул Филиппой 2-р бүлэгт өвдөг бүр сөгдөж, хэл бүр Есүс бол Эзэн гэж хүлээн зөвшөөрнө гэж бичсэн байдаг. Гол ялалтаа аль хэдийн байгуулжээ. Тиймээс зарим талаараа ялалт хүмүүсийн амьдралд биеллээ олсоор байгаа. Ариун Сүнсний хүчээр олон хүн өвдөг сөгдөн, Их Эзэнээ хүндэлж байгаа. Харин эцсийн тэр өдөр хүн бүр өвдөг сөгдөнө.

— Др. Д. А. Карсон

Бид Бурханы хаанчлалын гурван үет ялалтад Бурханы дайснуудын ялагдал багтдаг болохыг үзлээ. Одоо харин Бурханы хүмүүсийн аврал нь Шинэ Гэрээний теологид голлох үүрэг гүйцэтгэдэг тухай авч үзье.

Аврал

Хаанчлалын эхлэл үеийн ажлуудаас уншигч бүрийн анхаарлыг татдаг нэг зүйл бол Бурхан хүмүүсийг хаанчлалын ерөөлд оруулж буй аврал юм. Жишээлбэл, Сайнмэдээнд Есүсийн хийсэн гайхамшгуудын тухай ихээхэн ач холбогдол өгч дурдсан. Учир нь тэдгээр гайхамшгууд нь Есүсийн газар дэлхийд авчирсан хаанчлалын ерөөлийн нэгэн хэсэг билээ. Ирэх үед Бурханы хүмүүс тэдгээр ерөөлийг үүрд мөнх хүртэх билээ. Үүнээс гадна Есүс ядуу, эмзэг, бусдын гарт зовж шаналсан хүмүүст шударга ёсыг өгөхөд анхаарлаа хандуулж байсан. Энэ нь шударга ёс бол хаанчлалын ерөөлийн нэгэн хэсэг гэдгийг харуулдаг.

Гайхамшгууд болон Есүс, Түүний элч нар, эш үзүүлэгчдийн баримталж байсан нийгмийн шударга ёс бол гарцаагүй гайхамшигт ерөөлүүд байсан. Гэвч Бурханы хаанчлалын эхлэл үеийн хамгийн агуу ерөөл нь мөнхийн авралын бэлэг байсан бөгөөд Өөрт нь итгэдэг хүн бүрд Христ энэ бэлгийг өгсөн юм.

Ийм л учраас Колоссай 1:13-14 дээр Христийн дотор авралыг хүлээн авах нь нэг хаанчлалаас нөгөө хаанчлал уруу орж байгаа хэрэг гэж Паул тайлбарласан байдаг. Энд:

“Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна” гэжээ (Колоссай 1:13-14).

Хаанчлалын ерөөлийг хүлээн авч аврагдах тухай энэ сэдэв бидэнд Шинэ Гэрээнд Ариун Сүнсний ажлуудыг ихээхэн онцолсны учрыг ч ойлгоход тусалдаг. Газар дээрх үйлчлэлийн төгсгөлд Христийн дагалдагч нарын дээр Ариун Сүнс бялхан цутгасан нь итгэгч хүн бүрд ирээдүйд хүлээн авах их ерөөлийнх нь баталгаа болж өгсөн байдаг. Үүнийг бид 2 Коринт 1:21-22 дээрээс харцгаая. Энэ нь:

“Христ дотор биднийг та нартай хамт бататгаж тосолсон нь Бурхан мөн. Тэр биднийг бас тамгалсан ба зүрхэнд маань Сүнсийг барьцаа болгон өгсөн аж” гэжээ (2 Коринт 1:21-22).

Энэхүү эшлэл нь Ефес 1:14-р эшлэлтэй ижил утгатай. Эдгээр эшлэл дээр Ариун Сүнс бол “биднийг Өөрийн болгож тамгалсны” баталгаа гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Мөн Тэр бол “ирэх зүйлийн баталгаажуулсан барьцаа” юм. Өөрөөр хэлбэл бидний амьдрал дахь Бурханы хүч болсон Ариун Сүнс бол Христ алдар дотроо эргэн ирэх үед Христийн дагалдагчдын хүлээн авах агуу их өвийн урьдчилгаа гэсэн үг юм.

Мөн Шинэ Гэрээ нь бидэнд Христийн хаанчлалын үргэлжлэх үед ч Бурханы хүмүүсийн чөлөөлөлт байдаг тухай өгүүлдэг. Сүм чуулган өсөн хөгжиж байгаа энэ цаг үед ч Христийн дагалдагчид Бурхан тэднийг хэрхэн чөлөөлж, хаанчлалынхаа ерөөлд оруулсан гэдгийг санаж байх хэрэгтэй. үүнийг Шинэ Гэрээний бичээчид урамшуулан захисан юм. Бурхан биднийг гэм нүглийн шийтгэлээс авраад зогсохгүй Ариун Сүнсний бэлгээ сүм чуулгандаа үргэлжлүүлэн өгсөөр байдаг. Үүнийг Шинэ Гэрээний теологи бидэнд үргэлж сануулдаг. Жишээ болгож 1 Коринт 4:20 дээр хэрхэн хэлснийг харцгаая. Энд:

“Учир нь Бурханы хаанчлал ярианд бус, харин хүч дор байна” гэжээ. (1 Коринт 4:20).

Өөр олон эшлэлд бичигдсэнтэй адил энд Паул “хүч” гэж хэлэхдээ Ариун Сүнсний хүчийг хэлж байсан юм.

Бурханы Сүнс бол Түүний хүмүүс өдөр тутмын амьдралдаа мэдэрч байдаг, Бурханы ерөөлүүдийн гайхамшигт баталгаа мөнөөс мөн. Сүнс биднийг ариусгаж, амьдралд маань олон сайн үр жимс авчирдаг. Мөн дайсныг эсэргүүцэх хүч чадлаар биднийг тэтгэдэг. Өнөөдөр Христийн чуулганы олон урсгалууд итгэгчдийн амьдрал дахь Ариун Сүнсний үүрэг оролцоог чухалчлахаа багасгасаар байна. Гэсэн ч Христийн хаанчлалын үргэлжлэх үеийн туршид Ариун Сүнс нь бидний агуу их ерөөл байсаар л байх болно.

Шинэ Гэрээний теологи мөн хаанчлалын үргэлжлэн үед амьдарч байгаа Христитгэгчдийг хожим ирэх хаанчлалын илүү агуу ерөөлүүдэд итгэж найдахыг

уриалдаг. Еврей 12:28 дээр Христийн дагалдагчдыг хожим хүлээн авах ерөөлөө санан, итгэмжтэй байхыг ятгасан байдаг. Энэ нь:

“Иймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархлаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм” гэжээ (Еврей 12:28).

Мөн Иаков 2:5 дээр юу гэснийг харвал:

“Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайрлагсдад амласан хаанчлалын өвлөгчид болгож, тэднийг итгэлдээ баян байлгахаар сонгоогүй гэж үү?” гэжээ (Иаков 2:5).

Иаков чуулганы итгэгчдэд хандан баян байдаг гээд хаанчлал өвлөн авахгүй тул баян ядуугаар нь хүмүүсийг ялгахгүй байхыг заасан. Харин “итгэлээрээ баян” буюу “Есүст хайртай хүмүүс” “амлагдсан хаанчлалыг өвлөнө” гэж хэлсэн байна.

Есүс хаанчлалын суурийг тавихдаа л аль хэдийн Өөрийн хүмүүсийг чөлөөлж, хаанчлалын ерөөлд оруулсан. Тэгээд тэр ерөөл нь сүм чуулганы түүхийн туршид үргэлжилсээр байна. Гэхдээ бүрэн төгсөөр хаанчлалыг байгуулах тэр үеийг хүртэл энэ нь мөн бүрэн төгс гүйцэлдэхгүй гэдгийг Библи бидэнд заадаг. Харин хаанчлал бүрэн төгс байгуулагдах тэр үед л Бурханы хүмүүс хаанчлалын бүх амлагдсан ерөөлийг бүрэн дүүрнээр хүлээн авах болно. Илчлэл 11:15 дээр энэ талаар хэлэхдээ:


“Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийнх болсон. Тэр үеийн үед хаанчилна” гэжээ (Илчлэл 11:15).

Христ эргэн ирэхэд энэ дэлхийн хаанчлал Бурханы ялалт дүүрэн хаанчлалаар бүрэн солигдоно. Тэнгэр элч нар Христийг магтан дуулж буй тухай Илчлэл 5:9-10 дээр юу гэж бичсэнийг харцгаая. Энд:

“Хуйлмал номыг авч, Лацнуудыг нь нээх зохистой нь Та мөн. Учир нь Та нядлуулсан бөгөөд Өөрийн цусаар бүх овог, хэл, ард түмэн болон үндэстнүүдээс Бурханд ариун хүмүүсийг арилжин авч өгсөн билээ. Та тэднийг Бурханы маань төлөөх Хаанчлал ба тахилч нар болгосон. Тэд дэлхий дээр хаанчлах болно” гэжээ (Илчлэл 5:9-10).

Хаанчлал бүрэн байгуулагдах тэр үед Бурханы хүмүүс бүгд “хаанчлалын тахилч нар” болж “дэлхий дээр хаанчлах” болно.

Есүс эргэн ирж эцсийн ялалтаа байгуулах тухай бид бодохдоо Есүс дайснуудаа Францчуудын хэлдгээр *форс мажэ* буюу давагдашгүй хүчин зүйлээр бут цохино гэж бодож болохгүй. Илчлэл номд Есүсийг амандаа сэлэмтэй байна гэж хэлсэн нь мэдээж Үгийн





сэлэм, шударга ёсны сэлэм, бүхнийг илчлэн ил гаргах эцсийн шүүлтийн тухай ярьж байгаа юм. Үүнтэй адил ариун хүмүүсийн хувьд, Шинэ Гэрээний ойлголтоор бол гэрчлэл гэдэг нь гол сэдэв юм. Бүхий л амьдралынхаа туршид Есүст итгэх итгэлээ сахиж, дайснаа хайрлахын тулд нөгөө хацраа өгч, бусдын хувьд тэнэглэл мэт байсан ч хамаагүй хийх хэрэгтэй бүхнээ тэд гүйцээсэн. Тиймээс эцсийн шүүлт болоход, бүх зүйл илчлэгдэн, бүгд ил тод болж, үнэн ялах болно. Энэ нь ариун хүмүүсийн хувьд сайн мэдээ бөгөөд харин Есүсийг, түүний үгийг эсэргүүцдэг хорон муу хүмүүсийн хувьд муу мэдээ байж таарна.

— Др. Шон МкДонау

Ингээд бүгдээрээ Шинэ Гэрээний бичээчид Есүсийн мессиагийн ажлын үе шат бүрд Бурханы дайснуудыг ялан дийлж, Өөрийн хүмүүсийг хаанчлалын ерөөлд аваачихад анхаарлаа хандуулсан болохыг үзлээ. Эхэндээ эдгээр асуудлууд хоорондоо холбоогүй мэт санагдаж болох ч Христ доторх Бурханы хаанчлалд ялалт ирэх тухай сэдвийг хөндсөн тул Шинэ Гэрээний теологид уялдан холбогдсон маш чухал ойлголтууд байдаг.

Дүгнэлт

Энэ хичээлээрээ бид Шинэ Гэрээний теологи дахь Бурханы хаанчлалын тухай ойлголт хэр чухал болохыг авч үзлээ. Энэ ойлголт нь Шинэ Гэрээний жижигхэн нэг хэсэг биш бөгөөд харин ч Шинэ Гэрээг бичсэн хүмүүсийн хэлсэн заасан бүхний гол санааны үндэс суурь нь болсон юм. Бид мөн Хаанчлалын Сайнмэдээ ч хэчнээн чухал болохыг бид судаллаа. Мөн бид Шинэ Гэрээний теологи Христийн ирж буй хаанчлалын эхлэл, үргэлжлэл болон бүрэн төгс болох үе шатуудыг хэрхэн чухалд тооцдог тухай ярилцлаа.

Шинэ Гэрээнд итгэх итгэл бол бүхэлдээ Бурханы хаанчлалын тухай юм гэж хэлэхэд хэтрүүлсэн хэрэг болохгүйг бид мэдлээ. Шинэ Гэрээний теологийн гол заадаг зүйл бол Бурханы хаанчлалын ялалтын тухай Сайнмэдээ бөгөөд Христийн хаанчлалын гурван үед тэр ялалтыг хэрхэн байгуулж, байгуулсаар байгаа, мөн бүрэн байгуулах тухай л юм. Хаанчлалын тухай эдгээр үндсэн ойлголтууд бол Шинэ Гэрээний хамгийн чухал ойлголтууд юм. Энийг л маргалгүй санаж явах нь Шинэ Гэрээний теологийг ойлгоход туслах болно. Мөн бид Шинэ Гэрээний тухай сургаал номлолдоо баримтлах чиглэлтэй болох юм. Христийн доторх Бурханы хаанчлалын

тухай сэдэв бол Шинэ Гэрээний теологийн асуудал бүрийн үндэс суурь гэдэг нь эргэлзэх зүйлгүй билээ.

ХАМТРАГЧИД

Др. Симон Вибэрт (хөтлөгч) бол Оксфордын Их сургуулийн Вайклифе танхимын дэд захирал бөгөөд мөн Номлохуйн Сургуулийн захирлаар ажилладаг. Др. Вибэрт нь Теологийн Магистрын зэргээ Гласгоугийн Их сургуулиас, Үйлчлэлийн Доктор зэргээ Реформэд Теологийн сургуулиас, Дээд боловсролын Суралцахуй ба Заахуйн ухааны Бакалаврын зэргээ Оксфордын Их сургуулиас тус тус авсан. Мөн тэрээр Латимар Трастын захирал, Английн Эвангелийн Зөвлөлийн чуулганы гишүүн бөгөөд Үг ба Сүнсний Нөхөрлөлийн гүйцэтгэх захирлаар тус тус үйлчилдэг. Др. Вибэрт мөн Гэгээн Лукийн Вилбэлдон Парк чуулганы номлогчоор 8 жил үйлчилсэн. Тэрээр олон тооны теологийн ном, өгүүлэл бичсэн бөгөөд үүнд *Excellence in Preaching: Learning from the Best* (IVP, 2011); *Stress: The Path to Peace* (Inter-Varsity Press, 2014); болон *Lives Jesus Changed* (Christian Focus Publications, 2010) зэрэг номууд багтдаг.

Др. Константин Р. Кэмдбел бол Тринити Эвангеликал Дивайнити сургуулийн Шинэ Гэрээний туслах профессор.

Др. Д.А. Карсон бол Тринити Эвангеликал Дивайнити сургуулийн Шинэ Гэрээний судалгааны профессор ба Госпел Коалишн байгууллагын хамтран үүсгэн байгуулагч.

Рев. Майкл Ж. Глодо бол Флорида муж, Орландо хот дахь Реформэд Теологийн Семинарын Библийн судлалын туслах профессор.

Др. Ричард бол Гордон-Конвел теологийн сургуулийн теологийн профессор ба Академи харилцаа хариуцсан Дэд Ерөнхийлөгч.

Др. Шон МкДонау бол Гордон-Конвел теологийн сургуулийн Шинэ Гэрээний профессор.

Др. Экхард Ж. Шнабел бол Гордон-Конвел теологийн сургуулийн Шинэ Гэрээ судлалын Мари Ф. Рокфеллар ллонд танигдсан профессор.

Др. Марк Л. Страусс бол Сан Диего дахь Бетел сургуулийн Шинэ Гэрээний профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

басар – Сайнмэдээг авчрах, зарлах, тулаанд ялсан тухай мэдээг зарлах гэсэн утгатай еврей үг (хөрвүүлэг)

Түүний элч нар ба эш үзүүлэгчдийн үйлчлэлийг хэлдэг.

Христ – Грек хэлний “*хритос*” буюу “тослогдсон” ба “тослогдсон нэгэн” гэсэн утгатай; Хуучин Гэрээний Еврей хэлний “мессиа” гэдэг үгтэй нягт холбоотой.

христос – Христийг илэрхийлдэг грек үг (хөрвүүлэг). Энэ нь “тослогдсон нэгэн” болох “*машиах*” ба “мессиа” гэдэг үгийн Септуагинт дахь хувилбар.

бүрэн төгс болох үе – Христ эргэн ирж, түүхэн дэх Бурханы туйлын зорилгыг биелүүлэх тэрхүү эцсийн үеийн эхлэлийн гурав дахь буюу эцсийн үе шат

үргэлжлэх үе – Эцсийн үеийн эхлэлийн хоёр дахь буюу дунд шат. Энэ нь Христийн анхны ирэлтээс хойших, эцсийн ялалтаас өмнөх Бурханы хаанчлалын үе

эвангелион – “*авралын зар*” гэсэн грек үг (хөрвүүлэг) буюу шууд утгаараа “сайн мэдээ” гэсэн утгатай

авралын зар – шууд утгаараа “Сайнмэдээ” буюу Бурханы хаанчлал хүнээр болон Есүсийн ажлаар дамжин газар дэлхийд ирсэн тухай юм. Энэ нь Есүсийг Мессиа хэмээн итгэн хүлээн авагсдад Бурхан авралыг өгснөөр тэрхүү хаанчлал нь бүрэн төгс болж тэлсээр байх тухай тунхаг

ирэх юмсын эхлэл – ирэх үе нь эхэлчихсэн (“эхлэл тавигдсан”) боловч бүрэн дүүрэн ирээгүй буюу “аль хэдийн, хараахан” гэж үздэг эцсийн цаг үеийн талаарх үзэл хараа

эхлэл үе – ирэх юмсын эхлэлийн эхний үе шат. Энэ нь Христийн эхний ирэлт болон

Бурханы хаанчлал – бүх бүтээлийнхээ дээгүүрх Бурханы бүрэн эрхт, хувиршгүй захиргаа

мөнхийн, тэнгэрлэг Иерусалимыг дүрслэхдээ ашигладаг

машиах/мэшиах – тослогдсон нэгэн буюу “мессиа” гэсэн утга бүхий Еврей үг (хөрвүүлэг)

Мессиа – “тослогдсон нэгэн” гэсэн утгатай Еврей үг. Энэ үеэс ирэх үед аваачих Давидын удмын агуу Хаан буюу Грек хэлэнд “Христос” гэж орчуулдаг

олам хаба' – “ирэх цаг үе” гэсэн утгатай Еврей хэллэг (хөрвүүлэг). Энэ нь Бурхан Израильд өгсөн бүх амлалтаа биелүүлэх ирээдүйн цаг үеийг илэрхийлсэн рабби нарын ашигладаг хэлц үг

олам хазэ – “энэ цаг үе” гэсэн утгатай Еврей хэллэг (хөрвүүлэг). Уналтаас хойш оршин байсан гэм нүгэл, зовлон ба үхлийн энэ цаг үеийг илэрхийлсэн рабби нарын ашигладаг хэлц үг

Септуагинт – Хуучиг Гэрээний Грек орчуулга

Бүрэн эрх/бүрэн эрхт байдал – Бурханы тасралтгүй захиргаа ба бүх бүтээлийн дээгүүрх бүрэн төгс эрх мэдлийг илэрхийлдэг теологийн нэр томьёо

ирэх үе – Израильд рабби нар цөллөгийн дараах зөвт байдал, хайр, баяр хөөр болон амар тайван бүхий ирээдүйн цаг үеийг дүрслэхдээ ашигладаг байсан хэллэг. Энэ бол Бурханы бүх зорилго биелэх цаг үе

энэ үе – Израилийн ахлагч нар болон рабби нарын нүгэл, зовлон, үхлийн энэ цаг үеийг дүрслэхдээ ашигладаг үг

Сион – Иерусалимын өөр нэг нэр. Заримдаа Давидын Хот ба Бурханы Хотыг хэлдэг. Мөн Израилийг бүхэлд нь болон